**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2025 оны 07 сарын 09 өдөр          Дугаар А/264          Улаанбаатар хот

Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г нэгдүгээр, Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэрэгжүүлэхтэй холбогдох журам, зааврыг боловсруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Стратеги, төлөвлөлтийн газар, Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, эх баригч бэлдэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн боловсруулж батлуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

3. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Э.Мөнхсүх)-т, шаардлагатай хөрөнгийг байгууллагын төсөвтөө тусган хэрэгжүүлэхийг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД          Ж.ЧИНБҮРЭН

141251521

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 09 өдрийн A/264 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ЭХ БАРИГЧИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
## (2025-2028 он)

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн (оноор) | | | | Хариуцах байгууллага | Хамтран ажиллах байгууллага | Төсөв (сая₮) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2025 | 2026 | 2027 | 2028 | | | |
| ***Зорилт 1. Эх барихуйн тусламжийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын удирдамж, заавартай уялдуулж сайжруулах*** | | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.1.** Эх баригч мэргэжилтний мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх | | | | | | | | | |
| 1.1.1 | Эх баригчийн бие даан гүйцэтгэх үйл ажиллагааг холбогдох бодлогын баримт бичигт тусган батлуулах | Эх баригчийн бие даан гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлж, бодлогын баримт бичигт баталгаажиж хэрэгжсэн байна. | Эх баригчийн бие даан гүйцэтгэх үйл ажиллагааны журам, гардан үйлдлийн заавар боловсруулж хэлэлцүүлсэн байна. | Бодлогын баримт бичгүүд батлагдсан байна. | Бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлж, эх баригч бие даан ажиллах нөхцөл бүрдсэн байна. | | ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл | НҮБХАС, Үндэсний төвүүд, Амаржих газрууд, АЭМГ, НЭМГ | - |
| 1.1.2 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтний АТТ-д эх барихуйн тусламжийг хариуцан ажиллах чиг үүргийг нэмж тусган батлуулах | Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтний АТТ-д эх барихуйн тусламжийг хариуцан ажиллах чиг үүрэг батлагдсан байна. | АТТ-д заасан чиг үүргийн дагуу эх барихуйн тусламжийн бодлого, үйл ажиллагааг ЭМЯ, холбогдох газруудын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. | Эх барихуйн тусламжийн бодлого, үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу хийгддэг болно. | Эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар сайжирна. | | ЭМЯ | АЭМГ<br>НЭМГ<br>Төрөлжсөн мэргэжлийн төвүүд | - |
| 1.1.3 | ЭМЯ-ны дэргэдэх Эх барих, эмэгтэйчүүд судлал (ЭБЭС)-ын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийн 30 хүртэлх хувьд эх баригч мэргэжилтний төлөөллийг оруулж батлуулах | ЭБЭС-ын Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийн 30 хүртэлх хувьд эх баригч мэргэжилтний төлөөлөл орж, үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. | ЭБЭС-ын Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийн 30 хүртэлх хувьд эх баригч мэргэжилтний төлөөллийг оруулсан ЭМС-ын тушаал батлагдсан байна. | - | - | - | ЭМЯ | МЭБН<br>Мэргэжлийн салбар зөвлөл | - |
| 1.1.4 | Төгсөлтийн дараах мэргэшүүлэх хөтөлбөрийг "Эсэн мэнд амаржихуйн-Эх баригч", "Нийгмийн эрүүл мэндийн-Эх баригч, БНҮЭМ- | Эсэн мэнд амаржихуйн-Эх баригч, Нийгмийн эрүүл мэндийн -Эх баригч, БНҮЭМ-ийн-Эх баригч" төрөлжсөн мэргэшлээр | Эсэн мэнд амаржихуйн-Эх баригч, Нийгмийн эрүүл мэндийн-Эх баригч, БНҮЭМ-ийн-Эх баригч | Эсэн мэнд амаржихуйн-Эх баригч, Нийгмийн эрүүл мэндийн-Эх баригч, БНҮЭМ-ийн-Эх баригч | Тус бүр 10 мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. | Тус бүр 20 мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. | ЭМЯ-ЭМХЗ<br>ЭМХТ<br>АШУҮИС<br>БЯ | МЭБН<br>НҮБХАС | 10.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн-Эх баригч" мэргэшлээр мэргэжилтэн бэлтгэх | мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. | мэргэжилтэн бэлтгэх төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг батлуулсан байна. | төрөлжсөн мэргэшлээр бэлтгэх сургалтын хөтөлбөр батлагдаж, мэргэжилтэн бэлтгэж эхэлнэ. | | | | |
| 1.1.5 | Эх барихуйн мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд, дадлагажигч нарт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл" олгодог олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх | Эх барихуйн мэргэжлээр суралцаж байгаа оюутан, дадлагажигч нарт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл" олгодог болсон байна. | Эх барихуйн мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд, дадлагажигч нарт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл олгох эрх зүйн орчин, журам"- гүйцэтгэх гардан үйлдэл, ажилбарын жагсаалтыг бэлдэж хэлэлцүүлсэн байна. | Оюутан, дадлагажигч эх баригч нарын гардан үйлдэл, ажилбарын гүйцэтгэл, ур чадварыг үнэлж "Түр зөвшөөрөл" олгодог журамтай болсон байна. | Үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна. | ЭМХТ АШУҮИС | МСЗ МЭБН | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.2.** Эх баригчийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг боловсронгуй болгож, эх баригчаар удирдуулсан тэй БНҮЭМ, жирэмсэн, төрөлт, төрсний дараах тусламж, үйлчилгээ, хяналтыг бий болгох | | | | | | | | |
| 1.2.1 | Эх баригчийн албан тушаалын тодорхойлолт (АТТ)-д заасан чиг үүргийг бүрэн гүйцэтгэж байгаа эсэхэд суурь үнэлгээ хийх | Сонгосон ЭМБ-уудад үнэлгээ хийгдэж, гарсан зөвлөмжийн дагуу ЭМБ-уудын дүрэм, чиг үүрэгт эх баригчаар гүйцэтгүүлэх ажлыг тусгаж баталгаажуулсан байна. | Үнэлгээ хийх ажлын хэсэг, удирдамж батлагдаж, үнэлгээгээр суурь түвшин, түүнийг сайжруулах зөвлөмж, төлөвлөгөө гарсан байна. | ЭМБ-ууд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. | Явцын хяналт, үнэлгээ хийгдэж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна. | ЭМЯ ЭМХТ АЭМГ, НЭМГ Амаржих газрууд | МЭБН МСЗ | - |
| 1.2.2 | ЭМС-ын тушаалаар батлагдсан эх баригчийн албан тушаалын тодорхойлолт (АТТ)- ын үлгэрчилсэн загвараар ЭМБ бүр өөрийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний онцлогт тохируулан АТТ-ыг баталж, хэрэгжүүлэх | ЭМБ-ууд эх баригчийн гүйцэтгэх ажилтай нь уялдуулан АТТ-ыг баталж хэрэгжүүлсэн байна.<br><br>/Өрхийн ЭМТ, СЭМТ, Амбулатори/жирэмсний хяналтын кабинет, төрөх тасгийн гм/ | ЭМБ-ууд Эх баригчийн АТТ-уудыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | АТТ-д заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх сургалтуудтай болсон байна | АТТ-д заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар бүхий эх баригч ажиллаж эхэлсэн байна. | АЭМГ НЭМГ ЭМБ-ууд | ЭМХТ МЭБН | - |
| 1.2.3 | Эх баригчдын гардан үйлдлийн сурах бичиг боловсруулах | Олон улсын эх баригчдын гардан үйлдлийн сурах бичгийг эх баригчийн сургалтанд бүрэн ашигладаг болсон байна | Олон улсын эх баригчдын гардан үйлдлийн сурах бичгийг орчуулж, өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, хэвлүүлсэн байна. | Сурах бичгийг ашиглах сургалтуудыг зохион байгуулсан байна. | Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтад ашиглах сурах бичигтэй, бүх сургалтанд нэвтэрсэн байна. | АШУҮИС, СС Мэргэжлийн салбар зөвлөл | | 20.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.4 | Эх баригчийн гүйцэтгэх гардан үйлдлийн стандартыг шинэчлэн батлуулж, мөрдөх | Эх баригчийн гүйцэтгэх гардан үйлдлийн шинэ стандарт батлагдсан байна | Эрүүл мэндийн технологи MNS - гардан үйлдлийн стандартад эх баригчийн гүйцэтгэх үйлдлүүдийг нэмж тусган батлуулсан байна. | Стандартын сургалтуудыг зохион байгуулж, эх баригчдын 50% гардан үйлдлийг хийх ур чадвар эзэмшсэн байна. | Стандартад тусгагдсан гардан үйлдлийг гүйцэтгэх чадвартай эх баригчдын 70%-д хүрнэ. | Эх баригчдын > 85% нь гардан үйлдлийг хийх ур чадвартай болно. | ЭМЯ<br>ЭМХТ<br>АШУҮИС<br>МСЗ<br>МЭБЭЭНХ | СХЗГ<br>ЭХЭМҮТ<br>ЭНЭҮТ<br>НҮБХАС | - |
| 1.2.5 | Эх баригчаар удирдуулсан БНҮЭМ-ийн загвар кабинетууд байгуулахад дэмжлэг үзүүлэх | Эх баригчаар удирдуулсан БНҮЭМ-ийн загвар кабинетууд байгуулагдсан байна. | Эх баригч төвтэй кабинет, клиник байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх загвар, журам, зардлын төсвийг боловсруулж, батлуулсан байна. | Шинээр 12 кабинет байгуулна. | - | - | ЭМЯ<br>АЭМГ<br>НЭМГ<br>Мэргэж лийн салбар зөвлөл<br>МЭБН | НҮБХАС<br>Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ | 152.0 |
| ***Зорилт 2. Эх баригч бэлдэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй суралцах, карьерын хувьд өсөж дэвших боломжоор хангах*** | | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.1.** Эх баригч бэлдэх сургалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсад магадлан итгэмжлүүлэх, сургалтын чанарын үнэлгээг нэвтрүүлэх | | | | | | | | | |
| 2.1.1 | Эх баригч бэлтгэдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт Олон улсад мөрдөж буй эх баригчдын стандартын дагуу үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах | Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийгдэж, зөвлөмж хэрэгжсэн байна. | Үнэлгээ хийх ажлын хэсэг, удирдамж батлагдсан байна. | Үнэлгээ хийгдэж дүгнэлт зөвлөмж, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт батлагдсан байна. | Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, сургалты хөтөлбөрийг сайжруулсан байна. | Сайжруулж, баталгаажуулсан хөтөлбөр хэрэгжсэн байна. | АШУҮИС | БЯ<br>ЭМЯ | 50.0 |
| 2.1.2 | Эх баригч бэлтгэдэг АУС-иудын сургалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсын эх баригчдын холбооны магадлан итгэмжлэлд хамруулах | Хөтөлбөр нь ОУЭБХ-гоор батлагдсан, эсхүл ОУ-ын магадлан итгэмжлэл авсан АУС-ийн тоо нэмэгдсэн байна. | Эх баригч бэлтгэдэг хөтөлбөрийг Олон улсын эх баригчдын холбоогоор батлуулах эсхүл ОУ-ын магадлан итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажил хийгдсэн байна. | 1-2 АУС-ийн хөтөлбөр ОУЭБХ-гоор батлагдана. | 2 АУС-ийн хөтөлбөр ОУ-ын магадлан итгэмжлэл авна. | 3 АУС-ийн - хөтөлбөр шинээр батлагдаж, сургалтын чанар, үр дүнг тооцдог болно. | БЯ-БМИҮЗ<br>АШУҮИС | ОУЭБХ | - |
| 2.1.3 | Эх баригч бэлтгэх сургалтын чанарын шалгуур, үнэлэх аргачлалыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх | Үнэлгээний шалгуур, аргачлал батлагдсан байна | Үнэлгээний шалгуур, аргачлал боловсруу лах ажлын хэсэг байгуулагдаж, эхлүүлсэн байна. | Үнэлгээний шалгуур, аргачлал батлагдсан байна. | Сургалтын үнэлгээнд ашигладаг болсон байна. | Сургалтын чанар, үр дүнг тогтмол дүгнэж зөвлөмж хэрэгждэг болсон байна. | БЯ<br>ЭМЯ<br>ЭМХТ<br>АШУҮИС | | Улсын төсөв |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.2.** Сургалтын орчинг сайжруулж, тасралтгүй сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | | | | | | | | | |
| 2.2.1 | Эх баригч бэлтгэдэг Анагаах ухааны сургуулиудыг эмнэлзүйн ур чадварын | АШУҮИС-ийн Говь-Алтай, Дорноговь, Дархан-Уул аймаг дахь салбар АУС-иуд олон улсын | Олон улсын стандартад нийцсэн эмнэлзүйн ур чадварын сургалтын | 2 АУС олон улсын стандартад нийцсэн сургалтын иж бүрэн лаборатори | 3АУС сургалтын лаборатори | | АШУҮИС<br>Хувийн хэвшлийн АУС-иуд | БЯ<br>ЭМЯ<br>бусад ОУБ | Улсын төсөв<br>ОУБ-ын санхүү |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын лабораторийг бүсчилж байгуулах | стандартад эмнэлзүйн ур чадварын сургалтын иж бүрэн лабораторитой болсон байна. | танхим байгуулах, муляж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | той болсон байна. | той болсон байна. | | | | жилт |
| 2.2.2 | "А" зэрэглэлийн зарим Сумын Эрүүл мэндийн төвүүд, суман дахь Нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлзүйн ур чадварын сургалтын танхим байгуулж, тогтмол ажиллагаатай болгох | 10 ЭМБ олон улсын стандартад нийцсэн эмнэлзүйн ур чадварын сургалтын танхимтай болсон байна. | ЭМБ-д сургалтын танхим байгуулах, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгслийн зардлын тооцоо хийгдэжж, санхүүжилтийг шийдвэрлүүл сэн байна. | 2 ЭМБ-д сургалтын танхим байгуулагдсан байна. | 3 ЭМБ-д сургалтын танхим байгуулагдсан байна. | 5 ЭМБ-д сургалтын танхим байгуулагдсан байна. | ЭМЯ АШУҮИС | Орон нутгийн ЗДТГ, АЭМГ | Улсын төсөв Орон нутгийн хөгжлийн сан |
| 2.2.3 | Шинэ эх баригчийг ажлын байранд сургаж, дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ЭМБ-ууд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж шинэ эх баригчийн 100% сургадаг болсон байна. | Хөтөлбөрийн дагуу шинэ эх баригчийг сургах багш нарыг арга зүйгээр хангах сургалтууд хийгдэж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | ЭМБ-уудын > 60% нь сургалтын хөтөлбөрийн дагуу шинэ эх баригчийг сургасан байна. | ЭМБ-ууд **>85% нь** сургалтын хөтөлбөрийн дагуу шинэ эх баригчийг сургаж, дадлагажуулдаг болно. | Улсын хэмжээнд хэрэгжсэн байна. | ЭМЯ, ЭМХТ | ЭХЭМҮТ Амаржих газрууд, БОЭТ ЭМБ-ууд | - |
| 2.2.4 | Шинэ эх баригчийг ажлын байранд сургаж, дадлагажуулах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж, шинэчлэн сайжруулах | Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөр шинэчлэгдэн батлагдсан байна. | | | Хөтөлбөр үнэлгээ хийгдсэн байна | Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | АШУҮИС ЭМХТ МСЗ | МЭБН | Улсын төсөв |
| 2.2.5 | Эх баригч нарыг боловсролын зэргээ ахиулах, өсөж хөгжихөд дэмжлэг үзүүлэх | Магистр, доктор цолтой эх баригчийн тоо жил бүр нэмэгдсэн байна. | 3 эх баригчийг боловсролын зэрэг ахиулах тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан байна. | 3 эх баригчийг боловсролын зэрэг ахиулах тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан байна. | 5 эх баригчийг боловсролын зэрэг ахиулах тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан байна. | 5 эх баригчийг боловсролын зэрэг ахиулах тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан байна. | ЭМЯ БЯ | АШУҮИС Жайка ОУБ | 80.0 |
| 2.2.6 | Эх баригч нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх | Дотоодын болон ОУ-ын Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан, сэтгүүлд бүтээлээ нийтлүүлсэн эх баригчийн тоо нэмэгдсэн байна. | Эх баригч нарт эрдэм,шинжилгээ судалгааны ажлын сургалт зохион байгуулж, судалгааны ажлын грант олгох шалгууртай болсон байна. | Жил бүр 2-оос доошгүй эх баригчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг шалгаруулж, дотоод, гадаадын хурал, зөвлөгөөнд нийтлүүлсэн байна. | 2 -оос доошгүй бүтээл нийтлүүлсэн байна. | 2 -оос доошгүй бүтээл нийтлүүлсэн байна. | АШУҮИС-СС ЭМХТ | МЭБН НҮБХАС | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.7 | Эх баригч нарыг мэргэжлийн англи хэлний хөтөлбөрт хамруулах | Анагаахын англи хэлний сургалтын хөтөлбөрт эх баригчдыг хамруулж ур чадварыг дээшлүүлсэн байна. | Эх баригчид сургалтын дэмжлэг үзүүлэх англи хэлний сургалтын төвүүдтэй удаан хугацаанд хамтран ажиллах гэрээ хийгдсэн байна. | 15-20 эх баригчийг сургаж, үр дүнг тооцсон байна. | 30 эх баригчийг сургаж, үр дүнг тооцсон байна. | 30 эх баригчийг сургаж, үр дүнг тооцсон байна. | МЭБН НЭМГ, АЭМГ, Амаржих газрууд | НҮБХАС НҮБХС Сургалтын төвүүд ТББ | 30.0 |
| 2.2.8 | Эх баригчийн мэргэшлийн зэргийн шалгалтын тусгай шаардлага, шалгуурыг шинэчлэн боловсруулж, батлуулах | Мэргэшлийн зэргийн шалгалтын тусгай шаардлага, гардан үйлдлийн жагсаалт шинэчлэгдэж хэрэгжсэн байна. | Мэргэшлийн зэргийн шалгалтын тусгай шаардлага, гардан үйлдлийн жагсаалтыг эх баригчийн гүйцэтгэх чиг үүрэг, мэдлэг, ур чадвартай нь уялдуулан шинэчилэн боловсруулах | Мэргэшлийн зэргийн шалгалтын тусгай шаардлага, гардан үйлдлийн жагсаалтыг баталсан байна. | Мэргэшлийн зэргийн шалгалт авахад хэрэгжүүлсэн байна. | | МЭБН МЭБЭЭНХ | ЭМЯ-ЭМХЗ ЭМХТ АШУҮИС-СС | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.3.** Эх баригч солилцооны гадаад, дотоодын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | | | | | | | | | |
| 2.3.1 | Эх барихуйн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн сургагч багш /ментор/ бэлтгэх, сургагч багшийн тоог нэмэгдүүлэх | Гэрчилгээ авсан эмнэлзүйн сургагч багшийн тоо жил бүр нэмэгдсэн байна. | Эх барихуйн эмнэлзүйн сургагч багшид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулах журам, сургалтын хөтөлбөр батлагдсан байна. | Эх барихуйн эмнэлзүйн сургагч 10 багш шинээр бэлтгэгдэнэ. | 15 сургагч багш шинээр бэлтгэгдэнэ. | 20 багш шинээр бэлтгэгдэж, бэлтгэгдсэн сургагч багш нар сургалтуудыг явуулдаг болсон байна. | АШУҮИС ЭМХТ | НҮБХАС | 50.0 |
| 2.3.2 | Эх баригч нарыг дотоодын болон олон улсын солилцооны хөтөлбөрүүдэд хамруулж, сургах | ОУБ-тай хамтын ажиллагааг өргөжүүлж, жил бүр 15 эх баригч нарыг гадаад дотоодын хөтөлбөрт хамрагдсан байна. | Эх баригч солилцооны хөтөлбөрийн чиглэл, төлөвлөгөө, батлагдсан байна. | 15 эх баригч хөтөлбөрт хамрагдсан байна. | 15 эх баригч хөтөлбөрт хамрагдана. | 15 эх баригч хөтөлбөрт хамрагдана. | ЭМЯ ЭМХТ МЭБН | АШУҮИС НҮБХАС /Бусийн мэргэжилтнүүд Мичиганы Их Сургууль Японы эх баригчдын нийгэмлэг | Улсын төсөв /төрийн сан/ |
| ***Зорилт 3. Эх баригчийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, тогтвортой ажиллах ээлтэй орчин бүрдүүлэх*** | | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.1**.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогод эх баригч мэргэжилтний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, ур чадварын үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх. | | | | | | | | | |
| 3.1.1 | Эх баригчийн ажлын ачаалал, нийгмийн баталгаа, ажлын байрны өнөөгийн нөхцөл байдал, ажлын зураглалд үнэлгээ хийх | Үнэлгээ хийгдэж, зөлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө хийгдсэн байна. | Үнэлгээний ажлын хэсэг байгуулагдаж удирдамж батлагдсан байна. | Үнэлгээ хийгдэж, дүгнэлт, зөвлөмж, эх баригчийн ажлын байрны зураглал гарсан байна. | Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжиж, хяналт үнэлгээгээр үр дүнг нь тооцдог болсон байна. | | ЭМХТ МЭБН МЭБЭЭНХ | НҮБХС | 50.0 |
| 3.1.2 | Өрхийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS стандартад заасан | Өрхийн эрүүл мэндийн төв бүрт эх баригч орон тоогоор ажилладаг болсон | ӨЭМТ-үүдийн 10 %-д эх баригч ажилладаг болно. | ӨЭМТ-үүдийн 25%-д эх баригч ажилладаг болно. | ӨЭМТ-үүдийн 50 %-д эх баригч | ӨЭМТ-үүдийн 80 %-д эх баригч ажилладаг болно. | НЭМГ, АЭМГ ӨЭМТ-үүд | МӨАУМХ | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орон тоогоор эх баригчийг ажиллуулах | байна. | | | ажилладаг болно. | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.2** Эх баригч мэргэжлийг сурталчлах, алдаршуулах, ухуулга нөлөөллийг эрчимжүүлэх, эх баригчийн манлайллыг сайжруулах | | | | | | | | | |
| 3.2.1 | ЭМБ-ын удирдах албан тушаалд томилогдсон эх баригчийн тоог нэмэгдүүлэх | Удирдах албан тушаалд ажиллаж байгаа эх баригчийн тоо нэмэгдсэн байна:<br><br>Эх баригч – Сувилахуй эрхэлсэн дэд захирал<br>Эх баригч - менежер<br>Эх баригч - зөвлөх<br>Эх баригч - сургагч багш | Эх баригчдыг эмнэлгийн удирдлага, менежментийн сургалтад хамруулах квот нэвтрүүлж, сургалтанд , хамруулах удирдамж боловсруулж ЭМ-ийн яамны хөгжлийн зөвлөлөөр батлуулах . | Удирдах албан тушаалд томилог дон ажиллаж байгаа эх баригчийн тоо жил бүр нэмэгдэнэ. | Удирдах ажилтны тоо жил бүр нэмэгдэнэ. | Дэд захирал, Удирдла гын зөвлөлд ажиллаж байгаа эх баригчийн тоо нэмэгдсэн байна. | ЭМБ-ууд | ЭМХТ МЭБН | - |
| 3.2.2 | Монголын Эх баригчдын нийгэмлэгийн их хурлыг зохион байгуулж, нийгэмлэгийн дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх | МЭБН-ийн их хурал хуралдаж, нийгэмлэгийн дүрэм шинэчлэгдэн, дүрмийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг нээлттэй ил тод нэгдмэл үйл ажиллагаатай болсон байна. | МЭБН-их хурлын бэлтгэл ажлын удирдамж, батлагдаж, 2025 онд их хурал зохион байгуулагдсан байна. | Монголын Эх баригчдын нийгэмлэгийн их хурлаар шинэ дүрэм батлагдсан байна. | Дүрмийг хэрэгжүүлж ажилласан байна. | Дүрмийг хэрэгжүүлж ажилласан байна. | МЭБН МЭБЭЭНХ | НҮБХАС | - |
| 3.2.3 | Монголын Эх баригчдын нийгэмлэгийн ажлын албыг байгуулж, ажилтнуудыг орон тоогоор ажиллуулах | Ажлын алба байгуулагдаж, орон тооны ажилтантай болсон байна. | - | Ажлын албанд 2 мэргэжилтэн орон тоогоор ажилладаг болсон байна. | Нийгэмлэгийн ажлын албаны тайлан, мэдээ ил тод, тогмтол үйл ажиллагаатай болсон байна. | | МЭБН . МЭБЭЭНХ | ЭМХТ | - |
| 3.2.4. | МЭБН-ийн цахим хуудсыг хөгжүүлж, үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох | МЭБН-ийн цахим хуудас тогтмол ажилладаг болсон байна. | МЭБН-ийн цахим хуудасны загварыг шинэчилэх | Цахим хуудасны хөгжүүлэлт хийх гэрээт ажилтан тай болж, үйл ажиллагаа тогтмолжино. | Цахим хуудас тогтмол ажиллаж хандалтын тоо нэмэгдсэн байна. | | МЭБН МЭБЭЭНХ | | - |
| 3.2.5. | МЭБЭЭНХ-ны туршлагыг судлах | Туршлага судалж нэвтрүүлсэн байна. | Холбооны үйл ажиллагаатай танилцаж туршлага судалж, хэрэгжүүлсэн байна. | - | - | | МЭБН | МЭБЭЭНХ | - |
| 3.2.6. | МЭБН-ийн дэргэд “Залуу эх баригчдыг дэмжих бүлэг” байгуулах, шавилан сургах үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Залуу эх баригчдыг дэмжих бүлэг байгуулагдаж, үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Залуу эх баригчдыг дэмжих бүлэг байгуулагдана. | Үйл ажиллагаа ны төлөвлөгөө баталж, үр дүнг тооцож ажиллана | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | | МЭБН | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.7. | Туршлагатай эх баригчийг алдаршуулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах | Эх баригчийг алдаршуулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах өдөрлөг, уулзалтууд, цахим ярилцлага тогтмол зохион байгуулагдаг болсон байна. | Жилд 2-оос доошгүй удаа өдөрлөг, уулзалт, цахимаар зохион байгуулсан байна. | 3-аас доошгүй өдөрлөг уулзалт зохион байгуул сан байна. | 5 эх бариг чийн туршла гыг сурталч лах арга хэмжээ хийсэн байна. | 5 эх баригчийн туршлагыг сурталч лах арга хэмжээ хийсэн байна. | МЭБН | - | - |
| 3.2.8. | Олон улсын Эх баригчдын холбоотой хамтын ажиллагааг өргөжүүлэх, тус холбооны их хуралд эх баригч нарын төлөөллийг тогтмол оролцуулж байх | ОУЭБХ-той хамтын ажиллагаа өргөжиж эх баригчдын төлөөлөл ОУ-ын хуралд оролцдог болсон байна. | ОУЭБХ-той хамтран жил бүр 1 арга хэмжээг зохион байгуулна. | ОУЭБХ- той жил бүр 1-ээс доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна. | ОУЭБХ- той хамтын ажиллагаа тогтмолж сон байна. | - | МЭБН | - | - |
| 3.2.9. | Монголын эх баригчдын нийгэмлэгийн нэрэмжит шагналыг бий болгох | МЭБН-ийн нэрэмжит шагнал бий болж эх баригчдыг шагнаж урамшуулсан байна. | МЭБН-ийн нэрэмжит шагнал олгох журам, тавигдах шаардлага, шалгуурыг боловсруулж баталсан байна. | 2 эх баригчид нэрэмжит шагнал олгосон байна. | 3 эх баригчид нэрэмжит шагнал олгосон байна. | 3 эх баригчид нэрэмжит шагнал олгосон байна. | МЭБН | ЭМБ-ууд | - |
| 3.2.10. | "Эх баригч" цахим сонин гаргах, фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулах | "Эх баригч" цахим сонин гаргадаг болсон байна. | Цахим сонин, фэйсбүүк хуудасны загвар гаргаж, үйл ажиллагааг өргөжүүлсэн. | Цахим сонин гаргаж түгээдэг болно. | | | МЭБН | НҮБХАС | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.3.** Эх баригчийн үйл ажиллагаанд тавигдах чанар, аюулгүй байдал, ёс зүйн хэм хэмжээг сайжруулах | | | | | | | | | |
| 3.3.1. | "Эх баригч мэргэжилтний ёс зүйн дүрэм)-ийг боловсруулж, батлуулах | Эх баригч мэргэжилтний ёс зүйн дүрэм батлагдаж, мөрддөг болсон байна. | Эх баригч мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийн төслийг боловсруулж хэлэлцүүлсэн байна. | Ёс зүйн дүрэм батлагдаж, мөрддөг болно. | | | ЭМЯ ЭМХТ | МЭБХ НҮБХАС | - |
| 3.3.2 | Эх барихуйн тусламж, үйлчилгээнд "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах" ОУ-ын стандартуудыг нэвтрүүлэх | Эх барихуйн тусламж, үйлчилгээнд "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах" ОУ-ын зорилт стандартууд бүрэн хэрэгжиж, эх барихуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүсэх эрсдэл, тохиолдлын тоо буурсан байна. | "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах" ОУ-ын стандартуудыг хэрэгжүүлэх гарын авлага гаргаж, сургалтууд зохион байгуулагдаж, хяналт, үнэлгээний хуудсуудыг боловсруулж, ашигладаг болно. | ОУ-ын стандартын сургалтуудыг үргэлжлүү лэн зохион байгуулна. | Эх барихуйн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал хангагдаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлээс сэргийлнэ. | | ЭМХТ МЭБН | ЭМБ-ууд | - |

Эрүүл мэндийн сайдын 2025 оны ......
07.. сарын ...09.... өдрийн ...А/264... тушаалын
хоёрдугаар хавсралт

# ЭХ БАРИГЧИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (2025-2028 он)

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2025 | Хүрэх түвшин (оноор) | | | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2026 | 2027 | 2028 | |
| | | | | | | | |
| **Зорилт 1.Эх барихуйн тусламжийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын удирдамж, заавартай уялдуулж сайжруулах**<br>***Үйл ажиллагааны чиглэл 1.1.*** *Эх баригч мэргэжилтний мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх* | | | | | | | |
| 1. | Эх баригч бэлтгэх сургалтын чанарын үнэлгээ, Эх баригчийн бие даасан үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | Тоо | 1 | 1 | 2 | 3 | ЭМС, БС-ын хамтарсан тушаал<br><br>ЭМЯ-ны цахим хуудас |
| 2. | Эх баригчийг мэргэшүүлэх төгсөлтийн дараах батлагдсан хөтөлбөрийн тоо | Тоо | 5 | 1 | 1 | 7 | ЭМЯ-ЭМХЗ-ийн шийдвэр ЭМХТ |
| 3. | "Эсэн мэнд амаржихуйн-Эх баригч", "Нийгмийн эрүүл мэндийн- Эх баригч" мэргэшлээр бэлтгэгдсэн эх баригчийн тоо | Тоо | - | - | жилд тус бүр 10 эх баригч бэлтгэнэ. | тус бүр 20 эх баригч бэлтгэнэ. | Батламж/Гэрчилгээ |
| ***Үйл ажиллагааны чиглэл 1.2.*** *Эх баригчийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг боловсронгуй болгож, эх баригчаар удирдуулсан БНҮЭМ, жирэмсэн, төрөлт, төрсний дараах тусламж, үйлчилгээ, хяналтыг бий болгох* | | | | | | | |
| 4. | Эх баригчийн гүйцэтгэх гардан үйлдлийн стандартын хэрэгжилтийн хувь | Хувь | Суурь үнэлгээний хувь | >50% | 70%-д хүргэнэ. | > 85%-д хүргэнэ | Үнэлгээний тайлан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Эх баригчаар удирдуулсан БНҮЭМ-ийн загвар кабинетын тоо | Тоо | - | шинээр 10 кабинет | шинээр 10 кабинет | шинээр 15 кабинет | Үйл ажиллагааны тайлан |
| ***Зорилт 2. Эх баригч бэлдэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй суралцах, карьерын хувьд өсөж дэвших боломжоор хангах*** <br> ***Үйл ажиллагааны чиглэл 2.1.*** *Эх баригч бэлдэх сургалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсад магадлан итгэмжлүүлэх, сургалтын чанарын үнэлгээг нэвтрүүлэх* | | | | | | | |
| 6. | Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эх баригчийн тоо | Тоо | 2 | 20 | 40 | 50 | ЭМХТ-ийн шийдвэр Гэрчилгээ |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.2.** Сургалтын орчинг сайжруулж, тасралтгүй сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 7. | Шинээр эмнэлзүйн ур чадварын танхимтай болсон ЭМБ-ын тоо | Тоо | 1 | 1 | 3 | 5 | Тайлан |
| 8. | Шинэ эх баригчийн хөтөлбөрт хамрагдсан эх баригчийн эзлэх хувь | Тоо | - | 50% | 60% | >85% | ЭМХТ,<br>АЭМГ, НЭМГ,<br>ЭМБ-ын тайлан |
| 9. | АУ-ы болон боловсрол судлалын магистр, докторын цол хамгаалсан эх баригчийн тоо | Тоо | 1 магистр | 2 магистр | 2 магистр | 1 доктор | АУС-иудын Эрдмийн зөвлөлийн шийдвэр<br>Магистр, докторын батламж<br>ЭШС-ны ажлын эмхэтгэл |
| ***Үйл ажиллагааны чиглэл 2.3.*** *Эх баригч солилцооны гадаад, дотоодын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх* | | | | | | | |
| 10. | Гадаад, дотоод, солилцооны хөтөлбөрт хамрагдсан эх баригч /Эх баригч ментор/ -ийн тоо | Тоо | 5 | 15 | 20 | 25 | ЭМХТ-ийн тайлан Гэрчилгээ |
| ***Зорилт 3. Эх баригчийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, тогтвортой ажиллах ээлтэй орчин бүрдүүлэх*** <br> ***Үйл ажиллагааны чиглэл 3.1.*** *Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогод эх баригч мэргэжилтнийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нөөцийн асуудлыг тусгаж хэрэгжүүлэх* | | | | | | | |
| 11. | Эх баригч ажиллаж байгаа Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эзлэх хувь | Хувь | .... | 25% | 50% | 80% | ЭМХТ-ийн тайлан |
| ***Үйл ажиллагааны чиглэл 3.2*** *Эх баригч мэргэжлийг сурталчлах, алдаршуулах, ухуулга нөлөөллийг эрчимжүүлэх, эх баригчийн манлайллыг сайжруулах* | | | | | | | |
| 12. | ЭМБ-ын удирдах албан тушаалд ажиллаж байгаа эх баригч мэргэжилтний тоо | Тоо | ... | 25 | 30 | 40 | Тайлан |